



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/515

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн  
төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, 46.3, Засгийн газрын 2021 оны "Журам батлах тухай" 160 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны "Нээлттэй тендер шалгаруулалтаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай" 144 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны "Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай" А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Бага оврын усны машин худалдан авах /Ханх сум/ гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202312019 дугаартай тендерт 64,160,000 (Жаран дөрвөн сая нэг зуун жаран мянган) төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Арби Элеваторс" ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. "Арби Элеваторс" ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий "Захиалагчийн төлөөлөгч"-өөр Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-г томилж, бараа, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Ажлын хэсгийн ахлагч: Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
- Ажлын хэсгийн гишүүд: Б.Баасансүрэн (Ханх сумын Засаг даргын Тамгын газрын дарга)
- Э.Уртнасан ("Арби Элеваторс" ХХК-ийн захирал)
- А.Энхжаргал (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын нутгийн захиргааны байгууллагын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)
- Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Ё.Ариунзаяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн авто тээврийн улсын байцаагч)

3. Бага оврын усны машин худалдан авах /Ханх сум/ гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, барааг (үйлчилгээг) хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу



зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Б.Оюунтуяа)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Даваасамбуу)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ